

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ 2022 ОНЫ
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ,
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023.01.16

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Биеийн тамир, спортын улсын хорооны 2022 оны төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үндэслэл, үнэлгээний арга зүй

Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.3, 6.4-т заасан аргачлалыг удирдлага болгов.

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2019 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн А/297 дугаар тушаалаар баталсан "Биеийн тамир, спортын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр", мөн 2022 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2022 оны төлөвлөгөө"-ний биелэлтэд тусгагдсан арга хэмжээний хүрээнд хийсэн ажлын тайлантай танилцах, судлах түүнд тусгасан мэдээ, мэдээллийг ашиглан хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийг тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ажлын бодит үр дүнг, хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцлоо. Үүнд:

- "Бүрэн хэрэгжсэн"- 100 хувь (90-100 хүртэл хувь);
- "Хэрэгжих шатанд"-70 хувь (50-90 хүртэл хувь)
- "Хэрэгжилт хангалтгүй"- 30 хувь (10-50 хүртэл хувь);
- "Хэрэгжээгүй"-0 хувь (0-10 хүртэл хувь);
- "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй"

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Биеийн тамир, спортын улсын хорооны 2022 оны төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 7 арга

хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зорилтын дундаж үнэлгээгээр 88.57 хувьтай буюу “хэрэгжих шатанд” гэж үнэлэгдлээ.

Хүснэгт 1. Зорилт, арга хэмжээ бүрийн хэрэгжилтийн үр дүн

Д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх			
1	1. Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт		90%
2	2. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт		30%
3	3. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн		100%
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах			
4	4. Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх		100%
5	5. Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх		100%
6	6. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх		100%
7	7. Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал		100%

Хүснэгт 2.

Хэрэгжилт гаргах арга хэмжээний тоо		7
Бүрэн хэрэгжсэн	90-100%	6
Хэрэгжих шатанд	50-90%	-
Хэрэгжилт хангалтгүй	10-50%	1
Хэрэгжээгүй	0-10%	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	-	-
Хэрэгжилтийн дундаж		88.57%

Дөрөв. Дүгнэлт.

1. Биеийн тамир, спортын улсын хорооны 2022 оны төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 7 арга хэмжээнээс 7 арга хэмжээ үнэлэгдэж, хэрэгжилтийн үнэлгээ 88.57 хувьтай буюу “хэрэгжих шатанд” байна.

2. Бүрэн хэрэгжсэн арга хэмжээ нийт арга хэмжээний 85.71% /6/-ийг, хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ нийт арга хэмжээний 14.22% /1/-ийг тус тус эзэлж байна.

3. Агентлагийн даргын 2022 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан “Төрийн албан хаагчийн 2022 оны сургалтын төлөвлөгөө”-ний 1-д “Гадаадын богино хугацааны мэргэшлийн сургалтыг 2 жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж байгууллагын албан хаагчдын 40-өөс доошгүй хувийг хамруулах”, 2-т “Мэргэшүүлэх сургалт”-д ..., Ахлах түшмэлийн багц сургалтад шаардлага хангасан 2-оос доошгүй албан хаагчийг хамруулах”, 7-д “Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтад архивын эрхлэгч, бичиг хэргийн ажилтныг хамруулах” гэж тус тус баталсан арга хэмжээнүүдийн хэрэгжилт хангалтгүй байна.

Тав. Зөвлөмж

1. 2022 онд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөнд “Гадаадын богино хугацааны мэргэшлийн сургалтыг 2 жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж байгууллагын албан хаагчдын 40-өөс доошгүй хувийг хамруулах” гэж тусгасан арга хэмжээний биелэлтийг байгууллагын нийт албан хаагчдыг хувьд шилжүүлэн тооцвол 1 жилд 8 албан хаагчдыг хамруулахаас 2022 онд 1 албан хаагчийг хамруулсан нь “хэрэгжилт хангалтгүй” гэж үнэлэгдэж бусад арга хэмжээний үнэлгээнд нөлөөлж байх тул энэ арга хэмжээний биелэлтэд анхаарах.

2. Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 04 дүгээр зөвлөмжийн 3.5-д “Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлага болон ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээгээр зохих шалгуурыг хангасан, төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн, төрийн албан хаагчийг төрийн захиргааны ахлах, эрхэлсэн, тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамруулах захиалгаа албан тушаалын ангилал тус бүрээр гарган Удирдлагын академид жил бүрийн 1 дүгээр сард багтаан хүргүүлж, биелэлтийг хамтран тооцож байх.

3. “Төрийн албан хаагчийн 2022 оны сургалтын төлөвлөгөө”-ний 7-д “Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтад архивын эрхлэгч, бичиг хэргийн ажилтныг хамруулах” гэж баталсныг тайлагнаагүй нь хэрэгжээгүй гэж үзэхээр байх тул энэ сургалтыг 2023 оны сургалтын төлөвлөгөөнд тусгаж батлуулан, архивын эрхлэгч, бичиг хэргийн ажилтныг хамруулах нь зүйтэй байна.

ХЯНАСАН:
ХШУДАХ-ИЙН ДАРГА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСӨН:
ХШУДАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН



Н.БАТСҮХ

Ч.МӨНХЧУЛУУН

Журмын 4 дүгээр хавсралт

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ 2022 ОНЫ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022.12.23

Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилготот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдрэл, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	2	4	Албан хаагчдын сургалтын төлөвлөгөөний хүрээнд 3 албан хаагчид 7,592,000 төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн байна. Эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 3, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, дунд хугацааны давтан сургалтад 3, шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад 5 албан хаагч суралцсан. Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөгөлт-"Алсын хараа-2050" 40 цагийн сургалтад 2 албан хаагч, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны зайны сургалт, Жендерийн ахисан түвшний сургалт, Төрийн байгууллага дахь харилцаа, маркетинг сургалтад 6 албан хаагч хамрагдсан. Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн пүрэв гарагт зохион байгуулдаг "7:4:10" арга зүйн сургалтын хөтөлбөрийг байгууллагын албан ёсны ажлын группт	
			Ажлын байран дахь сургалт	2	4		
		Үүнээс	Мэргэшүүлэх сургалт	5	8		
			Туршлага солилцох арга хэмжээ	0	0		
			Бусад	2	6		
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	Эмэгтэй албан хаагч	-		20
				Эрэгтэй албан хаагч	-		23
				Удирдах албан тушаалтан	-		8
				Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-		35
		Үүнээс					

m

✓

12/23

		1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	95,45	<p>оруулж, мэдээллээр хангаж бүх албан хаагчид хамрагдаж байна.</p> <p>Худалдан авах ажиллагааны 960,000 төгрөгийн төлбөртэй 3 хоногийн цахим сургалтад 12 албан хаагчийг хамруулсан.</p> <p>Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэн Э.Энхсоёл нь зохион байгуулагч талын зардлаар 2022 оны 9 дүгээр сарын 07-16-ны өдрүүдэд Япон Улсын Шизуока мужид төрийн захиргааны чиглэлээрх сургалтад хамрагдсан.</p>	
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	Үүнээс	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	-		1
			2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-		1
				Эмэгтэй албан хаагч	-		1
			Эрэгтэй албан хаагч	-	0		
			Удирдах албан тушаалтан	-	0		
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	1		
		2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш	2,27		
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	8,0	8,5		<p>Нийт 4 төрлийн сургалтад 15 албан хаагчийн хамруулан 8,552,000 төгрөгийн зардлыг байгууллагаас санхүүжилт олгож, дэмжлэг үзүүлсэн.</p>

зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	5,6%	4 албан хаагч өөрийн хүсэлтээр төрийн өөр байгууллагад шилжин ажилласан байна.
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах					
4. Урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	-	5,7%	2022 онд үндсэн цалинд 565,001,195 төгрөг, нэмэгдэлд 157,434,737, урамшуулалд 55,194,259 төгрөг, унаа хоолны хөнгөлөлтөд 106,037,512 төгрөг, нийт 883,667,703 төгрөг зарцуулсан байна.
	4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	8,000	15,000	Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2022 оны Б/110 дугаар тушаалаар албан хаагчдад олгох нэг өдрийн хоолны зардлыг 14,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн. 2022 онд унаа, хоолны хөнгөлөлтөд нийт 106,037,512 төгрөг зарцуулсан байна.
5. Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш	100%	Тайлант оны 1 дүгээр улиралд ажлын байрны орчны сэтгэл ханамжийн судалгааг цахимаар авч дунг нэгтгэн удирдлагуудад танилцуулан холбогдох арга хэмжээнүүдийг аван ажиглаж байна.
6. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	1	Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2022 оны Б/132 дугаар тушаалаар 16 бүлгийн 33 төрлийн үзлэг, шинжилгээнд 44 албан хаагчийг бүрэн хамруулан 17,600,000 төгрөгийг зарцуулсан байна.
	6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	100	Эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, шинжилгээнд албан хаагчид хуваарийн дагуу 2022 оны 12 дугаар сарын 19, 21, 22-ны өдрүүдэд бүрэн хамрагдсан.

7. Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	100%	Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 101,552,500 төгрөгийг зарцуулсан байна. 2022 онд нийт 5 албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бөгөөд эдгээр албан хаагчдад 154,848,850 төгрөгийн буцалтгүй тусламжийг олголоо.
---	------	--	---	------	--

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА
НЭГТГЭСЭН:
ХАРЬДА БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ
НӨӨЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



О.БАТТУЛГА
Н.НАРАНГЭРЭЛ

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ 2022 ОНЫ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ,
АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2023.01.09

Улаанбаатар хот

1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх		
<p>1</p> <p>1. Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт</p>	<p>Мэргэшүүлэх сургалтад 14, бусад сургалтад давхардсан тоогоор 210, дотоодын их дээд сургуулийн магистрын сургалтад 1 албан хаагч суралцаж байна. Удирдлагын академийн 2022 онд улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэх сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөний дагуу Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, төрийн албан хаагчдын давтан сургалтад 3, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 3, төрийн албанд анх томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 3, "Алсын хараа-2050" богино сургалтад 2, "Худалдан авах ажиллагааны мэргэшлийн сургалт"-д 12, Төрийн албаны зөвлөгөөс зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй ба байгууллагын соёлгоо бүтээх нь" сургалтад 40, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Авлигын эсрэг хуулийн талаарх мэдээлэл" сургалтад 35, Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулсан "Жендерийн эрх тэгш байдлын тухай" сургалтад 42 албан хаагч хамрагдсан.</p>	<p align="center">100%</p>
<p>2</p> <p>2. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт</p>	<p>Япон Улсын Шизуока мужид 2022 оны 09 дүгээр сард Монгол Улсын болговсрол, спорт, газар тариалан, халамжийн салбарын мэргэжилтнүүдийг гадаад харилцаа, төрийн захиргааны чиглэлээр сургах сургалтад 1 албан хаагч хамрагдлаа.</p>	<p align="center">100%</p>
<p>3</p> <p>3. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн</p>	<p>"Худалдан авах ажиллагааны мэргэшлийн сургалт"-д 12 албан хаагч, Эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 1 албан хаагч, магистрын сургалтад 3 албан хаагч, нийт 15 албан хаагчийг 4 төрлийн сургалтад байгууллагын зардлаар суралцуулан 8,552,000 төгрөгийг байгууллагаас төлж, дэмжлэг үзүүлсэн. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд 2022 онд 2 албан хаагч томилогдож, байгууллагын санаачилгаар дээрх 2 албан хаагчийн 2022.12.30-ны өдөр чөлөөлсөн. 4 албан хаагч өөрийн хүсэлтээр төрийн өөр байгууллагад шилжин ажилласан.</p>	<p align="center">100%</p>

2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах

4	4. Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Биеийн тамир, спортын газрын даргын 2019 оны А/297 дугаар тушаалаар баталсан "Биеийн тамир, спортын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг 2022 онд хэрэгжүүлэх 2 зорилт, 6 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 95 хувь байна. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2022 оны Б/21 дүгээр тушаалаар 11 албан хаагчид Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг ахиулан буюу шинээр олгосон. Тайлант хугацаанд журмын дагуу нийт 25 албан хаагчийн цалингийн шатлал, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг нэмэгдүүлэн тогтоосон. 2022 оны байдлаар цалин хөлс, шагнал, урамшуулалд 883,667,703 төгрөг зарцуулсан. Цалин хөлс, шагнал, урамшуулалд зарцуулсан зардал нь байгууллагын нийт төсвийн 5,7 хувийг эзэлж байна. Албан хаагчдад сар бүр олгох хоолны хөнгөлөлтийн хэмжээг 2022 оны 10 дугаар сараас нэмэгдүүлэн нэгж үнийг 14,000 төгрөг болгосон. 2022 онд албан хаагчдад унаа, хоолны хөнгөлөлтөд нийт 106,037,512 төгрөгийг зарцуулсан.	100%
5	5. Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	Нийт албан хаагчдаас ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал, асуулгыг авсан ба удирдлагууд өрөө, тасалгааны нөхцөл байдалтай танилцаж, 2 өрөө засвар хийлгэх, парны секц нэмэгдүүлэх санал, хүсэлт гаргаснаас нэн шаардлагатай 1 өрөөнд засвар хийж, бүх өрөөнүүдэд богино долгионы зуух, жижиг оврын хөргөгч, ус буцалгагч олгосон. Мөн албан хаагчдыг улирлын томуу, цар тахлаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэн нэг удаагийн амны маск олгосон.	100%
6	6. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, албан хаагчид ажлын байран дээр эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг хангаж харьяа байгууллага "Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв"-тэй хамтран ажиллаж байна. Эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх 16 бүлгийн 33 төрлийн үзлэг, шинжилгээнд 44 албан хаагчийг 2022 оны 12 дугаар сард хамруулан 17,600,000 төгрөгийг зарцуулсан байна.	100%
7	7. Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	Албан хаагчдын ээлжийн амралт, тэтгэвэр, буцалтгүй тусламж олгох зэрэг асуудлыг Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад шийдвэр, байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-д заасны дагуу шийдвэрлэн ажиллаж байна. Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-д заасны дагуу нийт 8 албан хаагчийн хүсэлтийн дагуу цалинтай чөлөө олгуулах асуудлыг шийдвэрлүүлсэн.	100%

	<p>Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын дагуу 5 албан хаагчид нийт 154,8 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосон. 2022 онд нийт 3 ажилтанд нэг удаагийн түлээ, нүүрсний буцалтгүй тусламж, Монголын Үндэсний спортын VII наадам, Монголын Бүх ард түмний XV наадамд илүү цагаар ажилласан 11 албан хаагчдад 2,4 сая төгрөгийн нэмэгдэл хөлс, Үр дүнгийн үнэлгээний урамшуулалд 55,3 сая төгрөг, 12 албан хаагчид 4,8 сая төгрөгийн тэтгэмж, байгууллагаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 76 ахмад настанд 4,3 сая төгрөгийн дэмжлэг, 43 албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхээр 49,7 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон байна.</p>	
--	--	--

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

НЭГТГЭСЭН:
ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ
НӨӨЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



О.БАТТУЛГА



Н.НАРАНГЭРЭЛ